



БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБЯЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.01.07 № 01

Боловсролын зээлийн сангийн үйл
ажиллагааны хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн миний бие ахлан ажиллаж байна.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох мэдээллийг авах явцад дараах асуудлуудыг тодруулах шаардлагатай байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1.Боловсролын зээлийн сангаас хэрэгжүүлж буй Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг болон бусад хөтөлбөрүүдийн 2024 оны хэрэгжилт, тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан болон хамрагдсан суралцагчдын зүгээс тэтгэлэгтэй холбоотой ихэвчлэн ямар асуудлаар санал, гомдол, хүсэлт гаргадаг, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

2.Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтийн явц болон эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд хийгдэж буй ажил, төлөвлөгөө, хөндлөнгийн хуулийн байгууллагатай хамтран ажиллаж буй ажлын явцын талаарх мэдээлэл;

3.Дотоодын их, дээд сургуульд суралцагчдын зээл (оюутны хөгжлийн зээл)-ийн эргэн төлөлт 98 хувь, гадаадад суралцаж төгссөн оюутнуудын зээлийн эргэн төлөлт 4 хувь байна. Эргэн төлөлтийн байдал ийнхүү зөрүүтэй байхад Монголбанкны зээлийн мэдээллийн санд дотооддоо зээлээр суралцсан төгсөгчидийн зээлийн мэдээллийг бүртгэдэг боловч гадаадад зээлээр суралцсан төгсөгчидийн мэдээллийг бүртгэлжүүлэхгүй байгаа шалтгааны талаарх үндэслэл бүхий тайлбар;

4.2025 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сангийн нийт 158,4 тэрбум төгрөгийн батлагдсан төсвийн 33,6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт

2025000001

болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн. Уг санхүүжилтийг хэрхэн бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

5.Төрийн албан хаагчийг захиалгаар суралцуулж, чадавхжуулах бодлогыг хэрэгжүүлэхдээ Боловсролын зээлийн сангаас санхүүжүүлж буй зохицуулалт нь төрийн албыг мэргэшүүлэх ач холбогдолтой бөгөөд энэ талаар өмнө нь хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хамрагдсан төрийн албан хаагчийн тоо, сонгох шалгуурын талаарх мэдээллийг харьцуулсан байдлаар, мөн 2025 онд уг бодлогыг хэрэгжүүлэхэд төсөвлөгдсөн зардлын хэмжээг хэрхэн тооцсон талаарх төсвийн мэдээлэл;

6.Монгол Улсад нэн хэрэгцээтэй байгаа багш болон эрэлттэй бусад мэргэжлээр суралцагчдыг дэмжих хүрээнд Боловсролын зээлийн сангаас 2024 онд зарцуулсан төсөв, хөтөлбөрийн дүн, хэрэгжилтийн явц;

7.Дээрх хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас тогтоож байгаа эрэлттэй мэргэжлийн чиглэл нь оюутан, суралцагчдын Боловсролын зээлийн сангийн санхүүжилтэнд хамрагдахад хязгаарлалт болж байгаа эсэх, тийм бол энэ асуудлыг цаашид хэрхэх талаар баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл;

8.Боловсролын зээлийн сангийн сонгон шалгаруулалтын явцыг цахимжуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.БАТНАЙРАМДАЛ

2025000001